



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 08 өдөр

Дугаар А/74

Чингис хот

Аж үйлдвэрийн цахим мэдээллийн санд жижиг дунд үйлдвэр эр хлэгчдийг бүртгэх ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.1.6-ын "а", Их хурлын 2020 оны "Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 24 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийн системд аймаг орон нутагт үйл ажиллагаа явуулж буй эдийн засгийн "С" ангиллын боловсруулах үйлдвэрүүдийг бүртгэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн
ахлагч:

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга

Нарийн бичгийн
дарга:

Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн

Гишүүд:

Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга

Хэнтий аймаг дахь Улсын бүртгэлийн хэлтсийн дарга

Хэнтий аймгийн Татварын хэлтсийн дарга

Худалдаа аж үйлдвэрийн тэнхимийн Хэнтий аймаг дахь салбар тэнхимийн дарга

2. Аж үйлдвэрийн салбарын цахим мэдээллийг www.industry4.nda.gov.mn системд мэдээллийг шинэчлэн оруулах ажлыг 2 дугаар сард багтаан зохион байгуулж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагчид даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010219